

ШУТИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧДӨӨС ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТ АВАХ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ, ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. ШУТИС-ийн мэргэжлийн сургалттай бүрэлдэхүүн сургууль, МСҮТ, коллежийн мэргэжлийн анхан шатны болон техникчийн анги төгсөгчдөөс төгсөлтийн шалгалт авах, мэргэжлийн зэрэг олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. ШУТИС-ийн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын албанаас энэхүү журмыг баримтлан, сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд мэргэжлийн анхан шатны болон техникчийн анги төгсөгчдөөс төгсөлтийн шалгалт авах, мэргэжлийн зэрэг цол олгох ажлыг удирдлагаар хангаж зохион байгуулна.

1.3. Сургуулийн захиргаа төгсөгчдийн нэрсийн жагсаалтыг төгсөлтийн шалгалт эхлэхээс 2 сарын өмнө гаргаж ШУТИС-ийн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын албаар хянуулж баталгаажуулсан байна.

Хоёр. Төгсөгчдийг бүртгэх

2.1. Мэргэжлийн сургалттай бүрэлдэхүүн сургууль, коллеж, МСҮТ-ийн сургалтын алба сургалтын төлөвлөгөөнийн дагуу мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлээ бүрэн судлан шалгалт, шүүлгээ амжилттай өгч, үйлдвэрлэлийн дадлагын тайлан хамгаалж тэнцсэн суралцагчдыг зэрэгтэй төгсөх суралцагчаар, авбал зохих кредитийг бүрэн цуглуулсан, 60-аас доошгүй кредиттэй оюутныг техникчийн дипломтой төгсөх оюутнаар тус тус бүртгэж ШУТИС-ийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын албаар хянуулан Ректорын тушаал гаргуулна.

2.2. Тухайн мэргэжлээр суралцаж буй оюутан суралцах хугацаандаа хуримтлуулсан үнэлгээний голч дүн 2.5-аас дээш бол дипломын төсөл хийж, хамгаалж болно. Энэ тохиолдолд оюутан дипломын төслийн сэдэв, удирдагчаа өөрөө сонгож сургуулийн сургалтын албатай тохиролцон дипломын төслийн удирдагч, албан ёсны 2 зөвлөгчийг Ректорын тушаалаар томилуулах бөгөөд тухайн оюутан өөрийн сургуулийн аль ч багшаас зөвлөгөө авах эрхтэй.

Гурав. Төгсөлтийн мэргэжлийн шалгалт авах, мэргэжлийн зэрэг олгох комисс

3.1. Төгсөгчдөөс төгсөлтийн шалгалт авах, мэргэжлийн зэрэг олгох ажлыг тухайн сургуулийн саналыг үндэслэн ректорын тушаалаар томилогдсон нэгдсэн комисс зохион байгуулна.

3.2. Нэгдсэн комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн 5-7 хүнийн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд 40-өөс доошгүй хувь нь гадны төлөөлөл байна.

3.3. Төгсөгчдөөс мэргэжил тус бүрээр төгсөлтийн шалгалт авах 3-5 хүнтэй салбар комиссыг бүрэлдэхүүн сургууль, коллеж, МСҮТ-ийн захирлын тушаалаар байгуулна. Салбар комиссын дарга нь нэгдсэн комиссын гишүүн, гишүүдэд ажил олгогчдийн төлөөлөл, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын уг мэргэжлийн профессор багш нар болон тухайн сургуулийн багш нар байна.



Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн
... тоот тушаалын гуравдугаар хавсралт

3.4.Комисс нь төгсөгч нэг бүрийн эзэмшиж байгаа мэргэжлийн онолын мэдлэг, ур чадварыг үнэлж, чадамжид суурилсан сургалтын агуулга, стандартыг хэрхэн хангасан байдалд үнэлэлт, дүгнэлт өгч түүнд харгалзах мэргэжлийн зэргийг тодорхойлох үүрэгтэй

Дөрөв. Анхан шатны төгсөлтийн мэргэжлийн шалгалт авах

- 4.1.Тухайн мэргэжлийн сургалтын агуулга, хөтөлбөрийн дагуу судалвал зохих бүх хичээлүүдийг бүрэн судалж, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагыг шаардлагын дагуу гүйцэтгэсэн суралцагчийг төгсөлтийн шалгалтад оруулна.
- 4.2.Төгсөлтийн шалгалтыг тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийн агуулгын хүрээнд бэлтгэгдсэн иж бүрэн тест, төгсөлтийн өмнөх дадлагын тайлан хамгаалах аман ярилцлага, сорилын ажил хосолсон хэлбэрээр авна.
- 4.3.Төгсөлтийн шалгалтын иж бүрэн тестийг тухайн сургуулийн мэргэжлийн салбар /тэнхим/ дээр боловсруулж сургалтын албаар хянуулан, сургуулийн захирлын гарын үсэг, тамгаар батлагаажуулсан байна.
- 4.4.Төгсөлтийн шалгалтын үргэлжлэх хугацаа тухайн суралцагчийн хувьд нийт 3 хүртэл цаг байна.
- 4.5.Төгсөгч өөрийн хүсэлтээр эзэмшиж байгаа мэргэжлийнхээ ур чадварыг бүрэн харуулж чадах бүтээл хийж, аман ярилцлага болон сорилын ажлын шалгалтаа тооцуулж болно. Энэ тохиолдолд тухайн төгсөгчийн төгсөлтийн ажлын удирдагч буюу зөвлөгчийг сургуулийн захирлын тушаалаар томиллож ажиллуулна.
- 4.6.Төгсөлтийн шалгалт өгсөн суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг 100 оноогоор үнэлэх бөгөөд иж бүрэн тестийг 40, аман ярилцлагыг 30, сорилын ажлыг 30 хүртэл оноогоор тус тус дүгнэж, нийлбэрийг харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлэн үнэлэнэ.
- 4.7.Төгсөлтийн шалгалтын салбар комиссын гишүүд нь 4.6-д заасан оноогоор суралцагч тус бүрийг дүгнэх бөгөөд бүх гишүүдийн онооны нийлбэрийн дунджийг үсгэн үнэлгээнд шилжүүлэн эцсийн дүнг гаргаж комиссын хурлаар хэлэлцэн, протокол, үйлдэж нэгдсэн комисст ирүүлнэ.
- 4.8.Төгсөгчдөөс авах ерөнхий суурь буюу бүрэн дунд боловсрол олгох улсын шалгалтыг БСШУЯ-наас гаргасан зохих журмын дагуу оршин байгаа аймаг, хот, дүүргийн боловсролын газартай хамтран тухайн сургуулийн захиргаа зохион байгуулна.

Тав. Техникчийн төгсөлтийн шалгалт авах

- 5.1.Суралцах хугацаанд 60-аас дээш кредит цуглуулж сургалтын төлөвлөгөөнд заасан бүх шалгалт, шүүлгээ амжилтай өгсөн оюутнуудыг төгсөлтийн шалгалтанд оруулах бөгөөд шалгалтын үргэлжлэх хугацаа тухайн нэг оюутны хувьд 2 хүртэл цаг байна.
- 5.2.Төгсөлтийн шалгалтыг тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн агуулгын хүрээнд бэлтгэсэн иж бүрэн тест болон аман ярилцлага хосолсон хэлбэрээр явуулна.
- 5.3.Төгсөлтийн шалгалт өгсөн оюутны мэдлэгийг иж бүрэн тест 60 хүртэл, аман ярилцлага 40 хүртэл оноогоор дүгнэж , нийт 100 оноонд харгалзах үсгэн үнэлгээгээр үнэлэнэ.



Ректорын 2011 оны ...-р сарын ... өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт

5.4. Төгсөлтийн шалгалтын иж бүрэн тест болон аман ярилцлагын асуултыг мэргэжлийн салбар /тэнхим/ дээр мэргэжлийн багш нарын оролцоотой боловсруулж сургуулийн сургалтын албаар хянуулан зөвшөөрүүлж сургуулийн захирлын гарын үсэг тамгаар баталгаажуулсан байна.

Зургаа. Дипломын төсөл хамгаалах

6.1. Дипломын төсөл хамгаалалтын урьдчилсан дүн "С"-ээс дээш оюутан төгсөлтийн диплом хамгаалалтанд орно.

6.2. Төгсөлтийн комиссын нарийн бичгийн дарга удирдарч багшийн тодорхойлолтыг уншиж танилцуулсны дараа оюутан хийсэн дипломын төсөл, ажлаа 10 минутад багтаан ярьж /илтгэж/ хамгаална.

6.3. Төгсөгчийн дипломын төслийг 100 оноогоор үнэлэх бөгөөд удирдагч багшаас 50 хүртэл, урьдчилсан хамгаалалтаар 20 хүртэл, төгсөлтийн комиссын хамгаалалтаар 30 хүртэл оноо тус тус авна.

6.4. **Удирдагч багшийн үнэлгээ.** Багшийн үнэлгээний хамгийн их оноо 50 хүртэл байх бөгөөд ямар шалгуураар үнэлэхээ тодорхойлж тухайн мэргэжлийн салбар /тэнхим/ дээр зөвшилцсөн байна. Удирдагч багш урьдчилсан хамгаалалтаас долоо хоногийн өмнө дипломын төсөл, ажлын үнэлгээг тодорхойлолтын хамт дипломын төсөл, ажил хамгаалалтын комиссын нарийн бичгийн даргад хүргүүлнэ.


6.5. **Урьдчилсан хамгаалалт.** Урьдчилсан хамгаалалтыг дипломын төсөл, ажлын хамгаалалтаас долоо хоногийн өмнө холбогдох мэргэжлийн салбар /тэнхим/, төгсөлтийн комиссын нарийн бичгийн дарга нар хариуцан зохион явуулна. Урьдчилсан хамгаалалтаар төгсөх оюутанд 20 хүртэл оноо өгөх бөгөөд ажлын гүйцэтгэл, хамгаалсан байдлаас шалтгаалан удирдагч багшийн үнэлгээг бууруулж болно.

6.4. **Комиссын гишүүдийн үнэлгээ.** Комиссын гүшүүн бүр дипломын төслийн болон төгсөж буй оюутны суралцсан мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний хүрээнд асуулт тавьж диплом хамгаалалт, асуултанд хариулсан байдал, шүүмж, удирдагч багшийн тодорхойлолт зэргийг үндэслэн дипломын төслийн хамгаалалтыг 30 хүртэл оноогоор дүгнэх бөгөөд комиссын хурлаар хамгаалалтын урьдчилсан дүнг ахиулах буюу бууруулж болно.

Долоо. Мэргэжлийн зэрэг, үнэмлэх олгох

7.1. Мэргэжлийн анхан шатны анги төгсөгчдөд төгсөлтийн шалгалтын дүн, суралцах хугацааны ерөнхий үнэлгээ, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагын дүнг үндэслэн нэгдсэн комиссын хурлаар хэлэлцэн мэргэжлийн 1-4 дүгээр зэрэг олгоно.

7.2. Төгсөлтийн шалгалтын дүнг шалгалт авсан салбар комиссын хурлын шийдвэрт тусгагдсанаар, суралцах хугацааны ерөнхий үнэлгээг мэргэжлийн үнэмлэхэнд бичигдэх мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн дүнгийн дунджаар, үйлдвэрийн болон төгсөлтийн өмнөх дадлагын дүнг дадлага хийсэн ажил олгогчдын үнэлгээ, дадлагын тайлан хамгаалалтын дүнгийн дунджаар тус тус авна.



7.3. Сургуулийн сургалтын алба суралцах хугацааны ерөнхий үнэлгээ, үйлдвэрийн болон төгсөлтийн өмнөх дөдлагын дүнг шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө гаргаж тухайн суралцагчаар зөвшөөрүүлэн баталгаажуулсан байна.

7.4. Төгсөгчдийн мэргэжлийн зэргийн үнэлгээ нь 100 оноогоор үнэлэгдэх бөгөөд төгсөлтийн шалгалтын дүн-50, суралцах хугацааны ерөнхий үнэлгээ-30, үйлдвэрийн дадлагын дүн-20 хүртэл оноогоор дүгнэж нийлбэрийг харгалзах үсгэн үнэлгээнд шилжүүлэн дараах зэргүүдийг олгоно. Үүнд:

- 91-100 оноо А үнэлгээ дөрөвдүгээр зэрэг
- 81-90 оноо В үнэлгээ гуравдугаар зэрэг
- 71-80 оноо С үнэлгээ хоёрдугаар зэрэг
- 61-70 оноо D үнэлгээ нэгдүгээр зэрэг
- 60- аас доош зэрэг олгохгүй

Хэрвээ тухайн мэргэжлийн стандартаар мэргэжлийн өндөр зэрэг нь "1"-ээс эхлэдэг буюу өөр үнэлгээтэй бол дээрхи үнэлгээнд дүйцүүлэн мэргэжлийн зэргийг тогтооно.

7.5. Төгсөгчдөд мэргэжлийн зэрэг олгох асуудлыг нэгдсэн комиссын хурлаар хэлэлцэн протокол үйлдэж түүнийг үндэслэн мэргэжлийн зэрэг олгох тухай тогтоол гарган ШУТИС-ийн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын албанд ирүүлнэ.

7.6. Төгсөгчдөд мэргэжлийн зэрэг олгох нэгдсэн комиссын тогтоолыг үндэслэн ректорын тушаалаар төгсөгч нэг бүрт мэргэжлийн зэрэг олгоно.

7.7. Ерөнхий суурь буюу бүрэн дунд боловсрол олгох улсын шалгалт болон мэргэжлийн зэрэг олгох шалгалтаа амжилттай өгсөн суралцагчид мэргэжлийн боловсролын үнэмлэх, ерөнхий суурь буюу бүрэн дунд боловсрол олгох шалгалтанд F үнэлгээ авсан боловч мэргэжлийн зэрэг олгох шалгалтаа амжилттай өгсөн суралцагчид мэргэжлийн үнэмлэх тус тус олгоно.

7.8. Бүрэн дунд боловсрол олгох болон мэргэжлийн зэрэг олгох шалгалтаа амжилтгүй өгсөн, хүндэтгэх шалтгаангүй шалгалтанд ороогүй суралцагч дахин шалгалт өгөх хүсэлтээ сургуулийн захиргаанд гаргаж дараа жилийн төгсөлтөөр дахин өгч болно.

Найм. Техникчийн зэрэг, диплом олгох

8.1. Төгсөх оюутан төгсөлтийн шалгалт /дипломын төсөл/-ийг "С" буюу, түүнээс дээш үнэлгээтэй өгөх /хамгаалах/ үүрэгтэй. Төгсөлтийн шалгалтандаа амжилтгүй дүн авсан оюутны төгсөлтийг тодорхой хугацаагаар хойшлуулах бөгөөд уг хугацааг комиссын хурлаар тогтоож тогтоолд тусгана.

8.2. Төгсөлтийн комисс төгсөлтийн шалгалтыг амжилттай хамгаалсан оюутнуудын дүнг оюутан нэг бүрээр гарган баталсан шийдвэр болон төгсөгчдөд мэргэжлийн диплом олгох тухай тогтоол гаргана.

Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн
... тоот тушаалын гуравдугаар хавсралт



8.3.Төгсөлтийн комиссын тогтоолыг үндэслэн нэр бүхий төгсөх оюутанд ШУТИС-ийн ректорын тушаалаар тодорхой мэргэжлээр тусгай дунд боловсролтой техникчийн зэрэг бүхий диплом олгоно.

8.4.Техникчийн дипломын голч дүн 3.5-аас дээш, "А" үнэлгээтэй төгссөн оюутанд тухайн мэргэжлээрээ ШУТИС-д бакалаврын сургалтанд суралцах эрх олгож болно.